

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР БӨГӨӨД ҮЙЛДВЭРЛЭЛ
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГА

БАТЛМВ:

Н.БУЯН-ӨЛЗИЙ

Сэлэнгэ аймгийн сайхан сумын Хөтөл 1 дүгээр багт

**“Хүүхдийн паркийн” 3 га талбайд шилмүүст болон навчтит modoор ногоон байгууламж
бий болгох ажлын техникийн тодорхойлолт**

2024.05.28

1. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ	
1.1 Захиалагч байгууллагын нэр хаяг	"ЦЕМЕНТ ШОХОЙ" ХХК. Монгол улс, Сэлэнгэ аймаг, Сайхан сум, үйлдвэрийн байр
1.2 Төсөл хэрэгжих хүрээ	Сэлэнгэ аймгийн Сайхан сумын Хөтөл 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт байрлах талбайд ландшафт төлөвлөлтийн дагуу “Төгөл” байгуулах мод тарих ажил хийгдэнэ.
1.3 Ажлын нэр	“Тэр бум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Сэлэнгэ аймгийн сайхан сумын Хөтөл 1 дүгээр багт “Хүүхдийн паркийн” 3 га талбайд танин мэдэхүйн зориулалт бүхий төрөлжсөн төгөл байгуулах мод тарих 2-р ээлжийн ажил. шилмүүст болон навчтит modoор ногоон байгууламж бий болгох.
1.4 Ажил гүйцэтгэх үндэслэл	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хөрсний газрын доройтлыг багасгах, хүлэмжийн хийг бууруулах үйлсэд хувь нэмэр оруулах зорилгоор жишиг болохуйц цэцэрлэгжүүлэлт бий болгоход хийхэд оршино.
1.5 Мөрдөх дүрэм, журам	Шилмүүст модыг тарихдаа Монгол Улсын стандарт MNS 6139:2010 стандартыг баримтлах, навчтит модыг тарихдаа Монгол Улсын MNS 6141:2010 стандартын дагуу, суулгацын нүхийг бэлтгэхдээ Монгол Улсын стандарт MNS 6258-1:2011 стандартыг баримтлана.

1.6 Ажлын хэмжээ, шаардлага

1. Нарс 1-1.5 м, 210 ширхэг
Гадна талбайн тохижилтонд зориулан тарихад тохиромжтой мөнх ногоон мод юм. Үндэсний хөгжил хангалттай олон сайн байх нь хааш хаашаа маш их тэлж ургадаг учраас шим тэжээлээ хангалтай олж авдаг.
2. Агч/ногоон/ 1-1.5 м, 212 ширхэг
Ганд тэсвэрлэх чадвар дунд зэрэг, хүйтэнд тэсвэртэй. Гоёл чимэглэлийн ганц нэгээр болон бусад зүйлийн мод буттай хослуулан төгөл байгуулан тарихад тохиромжтой.
3. Долоогон 1 м, 73 ширхэг
Долоогонын мод нь хүйтэнд тэсвэртэй, хөрс голдоггүй ургах чадвартай. Жимсний мод учраас бөөрөнхий эсвэл өндөг шиг зууван олон жимс боловсوردог. Найрлаганд нь С, Е аминдэмүүд, шар луувангийн эд элбэг агуулагддаг мод юм.
4. Голт бор 1 м, 165 ширхэг
Цэцэрлэгт хүрээлэн, ойн зурvas төгөл зэргийг байгуулахад нэн тааламжтай. Гоёл чимэглэлийн ач холбогдолтой шинэ таримал сөөглөг мод.
5. Тэсмэг 1 м, 15 ширхэг
Гоёл чимэглэлийн ач холбогдолтой шинэ таримал сөөглөг мод.
6. Сарнайн бут 1 м, 38 ширхэг
Сарнай бут нь хамгийн үзэсгэлэнтэй ургамал бөгөөд хамгийн их ашиглагддаг ургамал юм.
7. Бургас 1-1.5 м, 46 ширхэг
Бургас хамгийн найдвартай "байгаль хамгаалагч" болдог. Хөрс голохгүй хаана ч ургадаг учраас цөлжилтийн аюул нүүрлэсэн Монгол оронд хамгийн хэрэгтэй модлог ургамал юм.
8. Өрөл 1 м, 70 ширхэг
Жимсний мод цэцэрлэгт хүрээлэн болон төгөл байгуулахад тохиромжтой навчит мод юм.
9. Хайлаас 1 м, 2184 ширхэг
Хайлаас нь хуурайдуу хөрс нь сийрэг үржил шим муутай хөрсөнд ургах чадвартай хашаалж тариалахад хамгийн тохиромжтой навчит мод.

10. Шар хүйас 1 м хүртэл 2768 ширхэг
Модорхуу сөөглөг ургамал, ган болон хүйтэнд тэсвэртэй. Ургамлан хашлага хийхэд нэн тохиromжтой.

11. Буйлс 1 хүртэл, 52 ширхэг
Төгөл байгуулахад байгуулахад хамгийн тохиromжтой навчит мод. Мөчруүд нь насжилтаасаа хамаарч өнгөө хувиргадаг.

12. Гүйлс 1 м-ээс дээш, 134 ширхэг
Маш гоёмсог цэцэглэдэг, цэцэг нь бал агуулдаг төгөл байгуулахад өнгө үзэмжийг ихээр нэмэгдүүлнэ.

Нийт 5967 ш

Эхний үе шат

1. Мод тарих
2. Хөрс боловсруулах агротехникийн ажлыг хийх.
3. Шилмүүст модыг тарихдаа Монгол Улсын стандарт MNS 6139:2010 стандартыг баримтлан технологийн дагуу гүйцэтгэнэ.
4. Навчит модыг тарихдаа Монгол Улсын MNS 6141:2010 стандартын дагуу гүйцэтгэнэ.
5. Суулгацын нүхийг бэлтгэхдээ Монгол Улсын стандарт MNS 6258-1:2011 стандартыг баримтлан гүйцэтгэнэ.
6. Модыг тарихдаа хөрсөнд тохирсон бордоо хэрэглэх.

Дараагийн үе шат

- 3 га талбайд таригдах тарьцыг услах, усалгааны системийг байнгын тогтмол усалгааны систем байхаар тооцож шийдвэрлэх /2024 оны 7 сард багтаан гүйцэтгэх;
- Тарих модны нүхийг бэлтгэх болон агротехникийн ажил гүйцэтгэх, хөрс боловсруулах, нүх ухах, бууц бордоо татаж бэлдэх 8 сард ;
- Тарьц суулгацыг бэлэн байлгах /9-р сард/
- 3 га талбайд Мод тарих, суулгах ажлыг 10-р сард;
- Модыг суулгаж дууссан байх 10-р сарын 30 хүртэл;
- 1-р ээлжийн мод бутны ургалт амьдралтын хувийг хянан тайлан мэдээ ирүүлэх, тайлан мэдээний дагуу бортоготой modoор нөхөн тарильт хийх 2024 оны 7,8 сард
- Шилмүүст, навчит модыг нэмэлт бордоогоор бордох 2024-2025 он дуустал тогтсон хугацаанд;

1.7 Гүйцэтгэх ажил

- Хог ургамал өвчин хортонтой тэмцэх ажлыг тогтмол хийх 2024-2025 он дуустал/
- Усалгааг тогтмол хийх 2024-2025 он дуустал/
- З га талбайд ландшафт зураглалын дагуу тарилт хийх 9 - 10 сард
- Тухайн талбайг тогтмол арчлах хүн хүчийг шийдвэрлэх 2024-2025 он дуустал
- Шилмүүс мод нь бортоготой байх, мөн бортогоноос дээшээ 1-1.5 м байх

2. ТАВИГДАХ ШААРДЛАГА

2.1 Голлох мэргэжилтэнүүд	Экологич болон Ойн инженер, ерөнхий мэргэшсэн инженер ажиллах хүчтэй, мэргэжлээрээ 2-с доошгүй жил ажилласан байх.
2.2 Техник хэрэгсэл, тоног төхөөрөмж	Нүх ухах зориулалттай тоног төхөөрөмж, техник хэрэгсэлтэй байх.
2.3 Ажлын туршлага	Ойжуулалт, мод үржүүлгийн чиглэлээр мэргэжлийн байгууллага тарьц, суулгацын нөөцтэй, ногоон байгууламж, төгөл бий болгож усалгаа, арчилгааг хийж байсан дадлага туршлагатай, өмнө нь энэ чиглэлээр 2-оос доошгүй ажил гүйцэтгэсэн байх.

3. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА

3.1 Хугацаа	Гүйцэтгэгч боловсруулж Захиалагч хянан баталсан календарьчилсан төлөвлөгөөний дагуу ажил гүйцэтгэх хугацааг тооцно.
-------------	---

4. ТАЙЛАН МАТЕРИАЛ

4.1 Тайлан материал	<p>1. Ажлын усалгааны иж бүрэн зураг төсөл боловсруулж, нэгтгэн дүгнэж, ажлын эцсийн үр дүнгийн тайланг одоогийн мөрдөгдөж байгаа хууль, журмын дагуу боловсруулж өгөх.</p> <p>2. Бусад шаардлагатай зураг мэдээллүүд багтсан байх.</p> <p>3. Гүйцэтгэгч нь хэвлэмэл тайлан, зураг болон бусад холбогдох бусад мэдээллүүдийг жилийн турш улирал бүр гүйцэтгэж хариуцсан хэлтэс, захиалагчид хүргүүлнэ.</p>
Төсөвт өртөг	200.000.000 сая төгрөг

АЖЛЫН ДААЛГАВАР ГАРГАСАН:

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН ГҮЙЦЭТГЭГЧ  З.БОЛОРТУЯА

ТӨСӨВТ ӨРТӨГ ХЯНАСАН:

БАЙГУУЛЛАГЫН НӨӨЦ ТӨЛӨВЛӨЛТИЙН
ЭДИЙН ЗАСГИЙН ХЭЛТСИЙН ДАРГА



Х.БАТСҮРЭН